

БАТЛАВ: БАЙГАЛЬ ОРЧИН УУР АМЬСТАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ-НЫ
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

.....Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“МОНИТАЛ КАШЕМИР” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....Ж. ОДОНЧИМЭГ

**“МОНИТАЛ КАШЕМИР” ХХК-ИЙН “НООЛУУР БОЛОВСРУУЛАХ
АНХАН ШАТНЫ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

БГД-ийн 29-р хороо, Нөхөрлөлийн гудамж, 1-31 тоот

РД: 2550229

Хянасан: БОУАӨЯ-ны үнэлгээ аудитын хэлтсийн
мэргэжилтэн...../

Боловсруулсан: “Монитал Кашемир” ХХК-ны СБО-ны
мэргэжилтэн...../ Ц.Амарсайхан/

УБ хот 2025 он

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	1
1.2 Төслийн хүчин чадал:	2
1.3 Ямааны ноолуур ангилан ялгах технологи ажиллагаа:	2
1.4 Түүхий эд туслах материал.....	4
1.5 Төслийн усан хангамж.....	5
1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр.....	5
1.7 Химийн бодис.....	5
ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ.....	6
2.1 Газрын гадарга, газарзүйн байршил	6
2.2 Гадаргын болон газрын доорх ус	6
2.3 Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг.....	6
2.4 Нийгэм эдийн засгийн тодорхойлолт.....	7
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
3.1 Агаар орчинд үзүүлэх нөлөөлөл	8
3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл	8
3.3 Усан мандалд нөлөөлөх магадлал	8
3.4 Нийгмийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал	9
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
4.1 Байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөөний зорилт	11
4.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
4.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	15
4.4 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
4.5 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	15
4.6 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал	17
4.7 БОМТ-г хэрэгжилтийн тайланг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах хуваарь	18
4.8 Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	19
ХАВСРАЛТ НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС.....	21
ХОЁР. ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	22
ГУРАВ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ.....	23
ДӨРӨВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
ТАВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ.....	25

ЗУРГАА. ДАТА МЭДЭЭЛЭЛ	26
ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН.....	27
НАЙМ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨӨНИЙ ДҮН	28

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	“Ноолуур боловсруулах анхан шатны үйлдвэр”-ийн төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	Италийн хөрөнгө оруулалттай “Монитал кашемир” ХХК, УБД: 9019003150, РД: 2250229
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 29-р хорооны нутаг дэвсгэрт, Нөхөрлөлийн гудамж 1-31 тоот, Утас 88113134
Төслийн байршил:	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 29-р хорооны нутаг дэвсгэрт, Гурвалжингийн гүүрний баруун талд 1.8 га талбай



Зураг1. Төсөл хэрэгжиж байгаа талбайн байршлын зураг



Зураг 2. Төслийн үйлдвэрийн байр


1.2 ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ:

"Монитал Кашемир" ХХК нь 1997 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Итали улсын "Pettinature Di Verrone", Люксембургийн "SEFIT industries SA" компанийн оруулалттай байгуулагдсан. Тус компани нь байгуулагдсанаас хойш Ноолуурт анхан шатны боловсруулалт хийх зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа явуулж байгаа билээ.

Ноолуур угаах машин нь цагт 250-300кг ноолуур угаах хүчин чадалтай, цахилгаан зарцуулалт 120 кв/цаг, уур 1.2 Гкал/цаг, цэвэр ус 30м3/хоног. Тус үйлдвэр нь хоногт 2 тн, сард 40тн ноолуур угаах хүчин чадалтай хэдий ч улирлаас /түүхий эд бэлтгэлийн/ хамааран сар бүр өөр байдаг байна. Иймд жилд боловсруулах ноолуурын хэмжээг сүүлийн жилүүдийн тоо баримтад үндэслэн тооцоход 400тн байна. Үйлдвэрийн үйл ажиллагаа нь түүхий эдийн нийлүүлэлтийн хамаарлыг эс тооцвол тасралтгүй явагдана. Нийт 44 ажилтан, албан хаагчтай.

1.3 ЯМААНЫ НООЛУУР АНГИЛАН ЯЛГАХ ТЕХНОЛОГИ АЖИЛЛАГАА:

Технологи дарааллыг схем зураг №1-р үзүүлэв.



Схем зураг 1

Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн жагсаалт

Хүснэгт №1

№	Нэр төрөл	Марк	Тоо ширхэг	Тайлбар
1	Бохир ноолуур сэмлэж задлах машин	BO32-152	1	Дэвшилтэт технологи бүхий аюулгүй ажиллагаатай
2	Ноолуур угаах машин	JF-025-152-5000	1	Шахах хатаах хэсгийг шинэчилсэн
3	Ноолуур самнах машин (урт)	Snow Lotus BSLD-95	6 ш	Дэвшилтэт технологи бүхий аюулгүй ажиллагаатай
4	Ноолуур самнах машин (урт)	FA186/0703/9 0432	2ш	Дэвшилтэт технологи бүхий аюулгүй ажиллагаатай
5	Хялгас боловсруулах машин	BSLD-XV-07	8ш	Дэвшилтэт технологи бүхий аюулгүй ажиллагаатай
6	Лабораторийн тоног төхөөрөмж	OFDA 2000	1 иж бүрдэл	Иж бүрдэл шинэчлэн суурилуулсан
7	Агааржуулах систем	Canal air A0725	2 иж бүрдэл	Шинэчлэсэн болон нэмж суурилуулсан
8	Угаах дамжлагын бохирдсон ус цэвэрлэх байгууламж	Comecotech	1 иж бүрдэл	Дэвшилтэт технологи бүхий аюулгүй ажиллагаатай

Тус үйлдвэрийн технологийн шийдлийн гол зорилт нь ноолууран ширхэгт түүхий эдийг самнан хялгасыг нь ялгах замаар боловсруулалтын түвшинг дээшлүүлэн олон улсын стандартын шаардлагад тохирох экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаад зах зээлд нийлүүлэх явдал юм.

1.4 ТҮҮХИЙ ЭД ТУСЛАХ МАТЕРИАЛ

Орон нутгийн ТННЭ-ийн батламжлал бүхий хоршоодын бэлтгэн нийлүүлэгчээс MNS 38:2007 түүхий эд бэлтгэлийн стандартын дагуу бэлтгэгдэн ирсэн түүхий ноолуурыг ноолуурыг өнгө, микроноор ялгаж худалдан авч анхан шатны боловсруулалт хийдэг.

1.5 Төслийн усан хангамж

Ус сувгийн удирдах газартай гэрээний дагуу гүний худаг болон төвлөрсөн усны шугамд усны хэрэглээг хэмжигч тоолуур суурилуулж ломбо тавьж лацдсан бөгөөд сар бүр төлбөр тооцоог хийсээр ирсэн. Харин үйлдвэрлэлийн усны хэрэглээ нь хоногт 25-30тн ба уг усны хэрэгцээг 1994 онд “Ус” ХК-ний гүйцэтгэлээр ашиглалтанд оруулсан гүний худагаас хангадаг. Уг худгийг 05 сараас 08 сарын дунд хүртэл дунджаар 3 сар гаруйн хугацаанд ашигладаг.

1.6 Цахилгаан эрчим хүч, уур дулааны эх үүсвэр

Уг төсөл нь дэд бүтэц хөгжсөн нийслэлийн дүүрэгт байрласан төвийн цахилгааны эх үүсвэрт холбогдсон.

Дулааны эрчим хүчийг жил бүрийн 10-р сарын 01-ний өдрөөс 05-р сарын 01-ний өдрийг хүртэл Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-тай гэрээ байгуулан авдаг бөгөөд дулааны хэрэглээг хэмжих тоолуур суурилуулж ломбо тавьж лацадсан. Эдгээр эрчим хүч, дулааны зарцуулалтыг тоолуурын заалтын дагуу төлбөрийг сар бүр хийж байна.

1.7 Химийн бодис

Нийт 11 төрлийн химийн бодис үйл ажиллагаандаа ашигладаг бөгөөд химийн бодисын агуулахын тухай Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн дүгнэлтийг 2022 оны 07 сарын 27-ны өдөр, 2025 оны 04 сарын 26-ны өдөр тус тус гаргуулсан. Ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартын шаардлагыг хангасан дүгнэлттэй байна. 3 төрлийн химийн бодисын бохир ус цэвэршүүлэх байгууламжид, мөн 3 төрлийн химийн бодисыг ноолуур угаахад, 1 бодисыг ноолуур самнахад, 2 төрлийн бодисыг химийн лабораторид ашигладаг. Химийн бодис хадгалах агуулах нь 1 давхар, 48м² талбайтай, анхааруулах тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу байршуулсан, химийн бодис тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл (ХАЛМ) бэлтгэн хүн ашиглахад хялбар газар байршуулсан. Агуулахад химийн осол гарахаас урьдчилсан сэргийлэх, сэрэмжлүүлэх тэмдэглэгээ, дохио үг болон химийн осол гарсан үед ашиглах хамгаалах хувцас хэрэгсэл, шингээгч материал, шаардлагатай утасны жагсаалт, нүд угаагч, анхан шатны тусламжийн хайрцаг зэргийг байршуулсан.

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

2.1 ГАЗРЫН ГАДАРГА, ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ

Физик газар зүйн мужлалаар Хангай–Хэнтийн уулархаг их мужид хамаарна. Тогтцын хувьд Богд Хан Уул Хангай, Хэнтийн атираат бүсийн Хэнтийн хэсгийн баруун өмнөд талд оршдог.

Төсөл хэрэгжих талбай нь Туул голын татмын дээрх 1 дэнжийн хэсэгт байрлах ба газрын гадарга нь хойноосоо урагшаа бага зэрэг хэвгий тогтоцтой байна. Талбайн хэмжээнд орчин үеийн физик-геологийн үзэгдэл үйл явц хөгжөөгүй.

2.2 ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС

Сав газар: Төслийн талбай нь Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 29-р хорооны нутагт Туул голын сав газар байрладаг. Туул болон Сэлбэ голын цутгал нь судалгааны бүсийн гадаргуугийн усны зонхилох хэсгийг бүрдүүлж байна. Туул гол нь хотын урд хэсгээр зүүнээс баруун зүгт гүехэн урсдаг бөгөөд 49,840 км² сав газартай ба ердийн үед 704км урттай, дунджаар 35-75м өргөнтэй байдаг. Тус голын хотын ойролцоох хэсгийн жилийн дундаж урсац нь 26.6 м/с байдаг ба зундаа хамгийн багадаа 1.86м/с хүрдэг.

Улаанбаатар хотын ус хангамжийн төвлөрсөн эх үүсвэрийн газрын доорх усны гол нөөцийг бүрдүүлэгч нь голоцений настай аллювийн хурдас дахь ус агуулагч бүрдэл болохыг баталгаатайгаар тогтоосноос гадна тус бүрдлийг дээд үе, доод үе гэж усны ундарга, шүүрэлтийн итгэлцүүр, хурдасны литологиороо ялгаа бүхий 2 үед ангилан үзсэн байдаг.

2.3 ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ

Тус талбайн аллювийн нугын/аллювийн нугын давсархаг, хар хүрэн/сайр чулуурхаг хар хүрэн, толгодын хар хүрэн/нимгэн сайр чулуурхаг хар хүрэн, уулын хар хүрэн/уулын нимгэн хар хүрэн, уулын хар хүрэн/уулын нимгэн хар шороон хөрсний ангилалд хамаарч байна.

Төсөл хэрэгжиж байгаа бүс нутаг нь монгол орны ургамал-газарзүйн Хэнтийн уулын тайгын тойрог, Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрог гэсэн хоёр тойргийн уулзвар нутагт байгаа юм. Туул голын дагуу голын эргийн дагуу ледебурын бургас зонхилж, 8 зүйлийн бургас, лавро навчит улиас, монос, өрөл, долоогоно, улаалзгана зэрэг жимст бут цөөнгүй ургадаг. Хотын ногоон бүсэд голын дагуу 4443 га талбай буюу 75,2 мян.шоо метр нөөцтэй бургасан шугуй, 549 га талбай буюу 48,0 мянган шоометр нөөцтэй улиасан шугуй сийрэг тархана. Нийслэл хотын нутаг дэвсгэрт хээрийг бүрдүүлэх ургамалд крыловын хялгана, саман ерхөг, дэрвээн хазаар өвс, том цэцэгт дааган сүүл, сунагар биелэг өвс, агь, ишгэн шарилж, адамсын шарилж, ишгүй гичгэнэ, имт гичгэнэ, дагуур хатны өвс, арзгар согоот, алаг башир, одой далан түрүү, цэх түмэн тана, дагуур ганга зэрэг ургамлууд

зонхилон ургадаг. Гэхдээ үйлдвэрийн бүсийн талбай нь техногени өөрчлөлтөд их орсон учир ургамал ихээхэн давжаа, тачир болсон.

2.4 Нийгэм эдийн засгийн тодорхойлолт

Тус үйлдвэр Баянгол дүүргийн 29-р хорооны нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд тус дүүрэг нь Улаанбаатар хотын хүн ам шигүү суурьшсан хамгийн том дүүргийн нэг юм. Баянгол дүүрэг нь 380 км² газар нутагтай, 11000 гаруй хүн ам оршин суудаг.

Үйлдвэрлэл үйл ажиллагаа явуулж буй 29-р хороо нь нийт 3600 өрхтэй, 6007 хүн амтай 1780 өрхтэй, улсын томоохон байгууллагууд /бгд-ийн замын цагдаагийн хэлтэс, барилга угсралт компани/, бусад 260 гаруй аж ахуйн нэгжүүд болон худалдааны томоохон төвүүд /хархорин, барс-2, сандэй-2, гурвалжин зах/ төвлөрч үйл ажиллагаа явуулдаг.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1 АГААР ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Төсөл хэрэгжих орчин нь өнөөгийн байдлаар хүн, амьтан, ургамалд нөлөөлөхүйц агаарын ямар нэгэн бохирдолгүй байна. Тус үйлдвэрийн удирдлагын зүгээс агааржуулалтын хуучин тоног төхөөрөмжөө шинэчлэн, сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий агааржуулалтын систем суурилуулсан байна.

Үйлдвэрийн гэрэлтүүлгийг стандартад нийцүүлээлэн ажилчдын эрүүл мэндэд сөрөг нөлөөг багасгаж ба хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хангасан байна.

Хог хаягдлыг орчны агаарын чанарт нөлөөлөхөөс сэргийлэн зориулалтын талбайд ангилан гэрээт компаниар ачилт хийлгэж байна.

Үйлдвэрийн агаар орчин бохирдсоноос үйлдвэрт ажилчдын эрүүл мэндэд муугаар нөлөөлнө. Багаж техникийн дуу чимээ нь хүний сонсголд муугаар нөлөөлнө. Ноолуур, ноос боловсруулах үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүд доргио бага үүсгэдэг боловч зарим машин, тоног төхөөрөмжүүд ажиллах үедээ нэлээд чимээ шуугиан гардаг байна.

3.2 ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

"Монитал Кашмер" ХХК-ний ноолуур боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа нь хөрсний элэгдэл, бохирдолд шууд нөлөөлөхгүй боловч хөрс нь зам талбайг тохижуулж зүлэгжүүлээгүйгээс хүн, автомашины хөдөлгөөний улмаас элэгдэлд орох, ил задгай хог хаягдлын цэг байгуулснаас (ялангуяа ноолуур угаах цехийн тунгаагуурын лаг шавар) болон хогийн цэгийг ариутгаагүй удах, хогийг зохих график хуваарийн дагуу ачихгүй байх зэрэг шалтгаанаас хөрс бохирдох, мөн үйлдвэрлэлийн технологид нэлээд хэмжээгээр хэрэглэгддэг химийн гаралтай бодисыг буулгах үед алдаж асгах тохиолдолд газрын хөрс бохирдох зэргээр сөрөг нөлөөлөл гарах магадлалтай байна.

3.3 УСАН МАНДАЛД НӨЛӨӨЛӨХ МАГАДЛАЛ

Ноолуур боловсруулах нь үйлдвэрийн технологийн хэрэгцээт усыг өөрийн үйлдвэрт гаргасан гүний худгаас авдаг бөгөөд орчны гидрогеологийн нөхцөл, цооногийн геологи-техникийн зүсэлт зэрэг материалаас үзэхэд гүний уст үе нь Туул голын аллювиаль хурдас болох хайргатай элсэн gruntэд гаргагдсан учир шүүрэлтийн коэффициент өндөртэй, уст үе нь дээрээ ус үл нэвтрүүлэх үе давхаргагүй (түрэлтгүй) байна.

Төслийн байршлын урдуур өнгөрөх, Улаанбаатар хот орчмын усан сүлжээг бүрдүүлэгч Туул голын голдрилын өргөн 60-70м, гүн 0.7-1.5м, эргийн өндөр 1.0-1.5м. Голын хамгийн их зардал 1410 м3/с хүрсэн баримт бий. Олон жилийн дундаж зардал 22.9 м3/с. 23 жилийн ажиглалтын дүнгээс үзэхэд мөстөлт 11-р сарын сүүлчээс эхэлж, мөсөн бүрхүүл 73-138 өдөр үргэлжилдэг. Сүүлийн үед ус нь ёроолдоо хүртэл хөлддөг болсон. Үүнийг хотын усан хангамжийн эх үүсвэрүүдэд жилийн турш ус авч ашиглагдаас усны түвшин их

доошилсноор тайлбарлаж болно. Энэ нь хүний үйл ажиллагааны нөлөөгөөр голын горимд өөрчлөлт орж, түүний нөөцийг хомсдуулж байгаагийн жишээ юм.

3.4 Нийгмийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал

“Монитал кашемир” ХХК нь үйлдвэрлэл явуулах зориулалтын байрын эрүүл ахуйн шаардлагыг хөдөлмөр хамгаалалын гол асуудлуудтай холбон авч үзсээр байна. Үүнд: ажиллагсдын эрүүл ахуйд үйлдвэрийн хортой хүчин зүйлүүд нөлөөлхөөс хамгаалах, нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах техник хэрэгсэл, ариун цэврийн системийн сайжруулалтыг байнга хийсээр байна.

Хөдөлмөр хамгааллын дотоод журамд тус үйлдвэрийн бүхий л хүрээнд ХХАА-ны сургалтуудыг зохион байгуулах, хяналт тавих, ажиллагсдын гүйцэтгэх эрх, үүрэг, НБХХ хувцсыг олгох, аюулгүй ажиллагааны сургалт, тоног төхөөрөмж, ажлын байранд тавигдах техникийн болон эрүүл ахуйн шаардлагууд тусгагдсан байх ба журмыг бүх ажиллагсад чанд мөрдөн ажиллах үүрэгтэй.

Төслийн үйл ажиллагаанд удирдлага-зохион байгуулалтын дараах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж байна. Үүнд:

- Эрчим хүчний нөөц (цахилгаан, дулаан уур), түүхий эд (бэлтгэн нийлүүлэгчдээс хүлээн авсан ноолуур), туслах (баглаа боодол г.м) материалыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, бохирдлоос хамгаалах.
- Үйлдвэрлэлийн технологийн зориулалттай уур, ус, эрчим хүчний хэрэглээний нормыг хэрэглэгч (цех, тасаг, нэгж) мэргэжлийн байгууллагуудтай хамтран боловсруулах, тэдгээрийн хэрэглээг төгөлдөржүүлэх
- Хэрэглэгдэх химийн бодис (саван, бохир ус тунадасжуулах бодис) бусад материалуудын орцыг багасгах чиглэлээр судалгаа, туршилтын ажил явуулах.
- Ажиллагсдын эрүүл ахуйг хамгаалах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах талаар:
- Үйлдвэрлэлийн үед ажилчдад чихэвч, нүдний шил (шаардлагатай үед) зэрэг хамгаалах хэрэгслийг тогтмол хэрэглүүлэх,
- Тоос шороо, уурын сорох болон чийгшүүлэх системийг үйлдвэрлэлийн үед тогтмол ажиллуулж байх,
- Үйлдвэрлэлийн түүхий эд, боловсруулалтын туслах материалыг (саван, бохир ус тунадасжуулах бодис) зориулалтын агуулах саванд хадгалах,
- Технологийн зааварчилгаа, санамж, анхааруулга, гэнэтийн ослын үед авах арга хэмжээний талаар санамж дүрмийг холбогдох газруудад байрлуулах,
- Бохирын шугам (дамжлагын), лагийн талбай, хог хаягдлын цэгт тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийж байх,

- Ажлын байрны нөхцөлийг мэргэжлийн байгууллагаар хянуулж байх, зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлж ажиллах.
- Байгаль орчин, аюулгүй ажиллагааны сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн байгууллагатай хамтран нийт ажиллагсдыг сургалтад хамруулах,
- Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зааврыг ажилчдад тогтмол танилцуулж байх

Бохир усыг технологийн болон эрүүл ахуйн шаардлагын дагуу цэвэрлэн халдваргүйжүүлж хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх асуудал нь Монгол Улсын Байгаль Орчны тогтвортой байдлыг хангах, хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах чухал ач холбогдолтой.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ

Үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд хүн, байгаль орчин, орон нутагт сөрөг нөлөөгүй ажиллах, байгалийн баялгийг зохистой ашиглах, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй үйл ажиллагаа явуулж, байгаль орчныг хамгаалах нь бидний зорилго юм.

“Монитал Кашемир” ХХК нь 2024 онд Байгаль орчинд нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд нийт 4 822 000₮ төгрөгийг зарцуулахаар төлөвлөв. Энд тусгагдаагүй зардлууд нь үйл ажиллагааны болон хөдөлмөр хамгааллын зардалд тусгагдсан болно.

Хүснэгт №2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Нийт зардал 2025 он
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	Мян/төг	900 000₮
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	Мян/төг	370,000₮
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян/төг	-
4	ХАБЭА төлөвлөгөө болон удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Мян/төг	150,000₮
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Мян/төг	2,500,000₮
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Мян/төг	752000₮
7	Нөлөөллийн бүсийн иргэдэд тайлан тавих	Мян/төг	150,000₮
Нийт		Мян/төг	4 822 000₮

4.2 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө		Урьдчилан сэргийлэх бууруулах арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян,төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах аргачлал стандарт
Агаар орчин							
1	Төслийн үйл ажиллагаанаас агаар бохирдох, тээврийн хэрэгслийн утаа, хог хаягдал зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй	Тоосжилт ихсэх үед чийгшүүлэх арга хэмжээг цаг агаарын улирлын байдлыг харгалзан авах	Тоосжилт их хэсэгт	Дотоод зардал		Дулааны улиралд тоосжилт ихтэй өдрүүдэд	Агаарын тухай хууль, MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Монгол Улсын агаарын чанарын стандарт. MNS 5457: 2005; Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага
2		Тээврийн хэрэгслийг үзлэг, оношилгоонд оруулах	Тээврийн хэрэгсэл	2*22000	44000	2025 он	
3		Химийн бодистой харьцах үеийн ХАБЭА горимыг чанд мөрдөх, зөвлөгөө өгөх, анхааруулга, санамж хийж зохих газарт байрлуулах, сургалт зохион байгуулах	Лабораторт самбар байршуулах	50000*2	100000	2025 онд 2 удаагийн давтамжтай хийлгэх	
4		Агаарын чийгшлийн хэмжилтийг стандарт хэмжилзүйн байгууллагаар хийлгэх	Үйлдвэр, барилга байгуулам жид	Дотоод зардал		2025 онд 2 удаагийн давтамжтай хийлгэх	
5		Үйлдвэр, оффисоос гарч байгаа хог хаягдлыг ангилан ялгаж зориулалтын цэгт хаях дадал хэвшүүлэх	Төслийн талбайд	-	Хог хаягдлын менежмент арга хэмжээний зардал		
Нийт				400 000₮			

Гол ба болзошгүй сөрөг нөлөө		Урьдчилан сэргийлэх бууруулах арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян,төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах аргачлал стандарт
Усан орчинг хамгаалах тухай							
1	Бохирдлын эх үүсвэр шатах тослох материал, ахуйн бохир ус болно. Дээрх эх үүсвэрүүд нь гадаргын болон газрын доорх усыг шууд, шууд бусаар бохирдуулах, горимд өөрчлөлт оруулах магадлалтай	Бохир ус цэвэршүүлэх байгууламжийг сайжруулах эсвэл стандарт шаардлагад нийцтэл цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулах	Төслийн талбайд	1	Дотоод төлөвлөлтө өр	2025	Усны тухай хуулийн- 28-р зүйлийн 28.4-т - заасны дагуу - Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага. MNS4586-98 (СХЗҮТ, 1998.5.28-ны өдрийн 17 тоот тогтоол.) - Усан орчны чанарын хяналт шинжилгээ MNS4047-88 (УСТ-ын даргын 1988 оны 248 тоот тушаал), - MNS 6390:2013 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага - Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт - Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ/ - Усны тухай хуулийн 28.4 заалт, Усны тухай хуулийн 26-31 -р бүлэг, “Ус ашиглах гэрээний загвар”- БОНХ-ийн Сайдын 2013 оны А- 367 тоот тушаалын хавсралт
2	Бохирдлын эх үүсвэр шатах тослох материал, ахуйн бохир ус болно. Дээрх эх үүсвэрүүд нь гадаргын болон газрын доорх усыг шууд, шууд бусаар бохирдуулах, горимд өөрчлөлт оруулах магадлалтай	Ус ашигласны төлбөрийн цаг тухайд төлж барагдуулж байх	Төслийн талбайд	Тухай бүрт нь тоолуурыг заалтын дүнгээр төлөх		2025 турш	
Нийт				400 000₮			

Гол ба болзошгүй сөрөг нөлөө		Урьдчилан сэргийлэх бууруулах арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг /мян,төг/	Нийт зардал /мян.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах аргачлал стандарт
Хөрс болон ургамлан бүрхэвчийг хамгаалах тухай							
1	Төслийн үйл ажиллагааны улмаас газрын гадарга, хөрс эвдрэх, ургамлан бүрхэвч устгах	Үйлдвэрийн хаягдал бохир ус, угаалгын бодисоор хөрс бохирдож болзошгүй тул хөрсний бохирдлын хэмжээг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж байх	Төслийн талбайд	-	-	Хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5916 : 2008
2	Барилга байгууламж барих, төхөөрөмж суурилуулах, бүтээгдэхүүн ачиж буулгах үйл ажиллагаагаар хөрс эвдэрч бохирдох, шатах тослох материал, шингэн хаягдал хөрсөнд нэвчих замаар бохирдол үүсэж болзошгүй	Агуулахаас гарах хатуу болон ахуйн хуурай хог хаягдал, химийн бодисыг эмх цэгцтэй хадгалах, хяналт тавих, зайлуулах	Төслийн талбайд	100000	100000	2025	
Нийт				100000			

4.3 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /мян.төг/	Нийт зардал	Хугацаа	Эрхзүйн баримт бичиг
1	Төслийн байршил орчмын	Зүлэгжүүлэлт хийх	35м²	2	кг	35000	70000	2025.05-06	-
2	хүчилтөрөгчийн хангамжийг	Улиас тарих	Төслийн талбай	5	ш	20000	100000	2025.05-2025.10	Тэрбум мод хөтөлбөр
3	сайжруулах, агаарын бохирдлыг арилгах	Цэцгийн мандал хийх	Төслийн талбай	5	ш	40000	200000	2025.05-06	
Нийт				370000					

4.4 ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайн болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл болон археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холобогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

4.5 ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1		Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Үйлдвэрийн байранд	-	-	Өдөр бүр, тогтмол ажил эхлэхээс өмнө	
2		Ажиллагсадыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйлдвэрийн хэмжээнд	-	-	Жил бүр	

3	Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх Технологийн хоцрогдол	Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт	Үйлдвэрийн бүх ажилчдад	Дотоод зардлаар		2025	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 27.1, - MNS4968:2000. ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага - MNS4995:2000. ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага - MNS5010:2001. ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага” MNS5078:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага - MNS5105:2001. Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, тавигдах шаардлага - MNS ILO OSH1:2003. ХААЭА-н удирдлын тогтолцооны талаарх удирдамж - MNS ILO OSH0:2003. ХААЭА. Шуугиан хэмжихэд
4		Үйлдвэрийн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт	Үйлдвэрийн бүх ажилчдад				
5		Үйлдвэрийн ажилчдад химийн бодистой ажиллах, аюул ослын үед авах арга хэмжээний сургалт	Үйлдвэрийн бүх ажилчдад				
6		Байгаль орчныг хамгаалах талаарх сургалуудыг зохион байгуулах	Үйлдвэрийн бүх ажилчдад				
7		Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийг бүрэн хангах арга хэмжээ авах, галыг унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах	Үйлдвэрийг бүхэлд нь -	ABC хор-45000*1 Бөмбөлгөн хор-33000*3	150000	2025	
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Менежментийн баг	Дотоод зардлаар		2025	
9		Цахилгааны сүлжээний бүрэн бүтэн байдалд мэргэжлийн байгууллагаар үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулж байх	Төслийн хүрээнд			2025	
10		Химийн хорт болон аюултай бодисын тухай" хуулийн 8, 9,10,12,13,14,17,18 дугаар зүйл, заалтуудыг тогтмол мөрдөж ажиллах	Менежментийн баг			2025	
11		Дамжуулах шугам хоолойнууд, тэдгээрийн	Төслийн хүрээнд			2025	

		холболтын эд ангиуд болон нээх хаах арматуруудын битүүмжлэлүүдийг байнга шалгаж, засвар үйлчилгээг цаг тухайд нь хийх				тавигдах ерөнхий шаардлага MNS5002:2000. ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS5390:2004. ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага -MNS ISO13688:2000. ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага - Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль - MNS 4996 : 2000. “Ажлын байрны гэрэлтүүлгийн норм” - MNS 5078 : 2001. “Үйлдвэрийн барилгын салхивч, агааржуулалтын системд тавих ерөнхий шаардлага”
12		Үйл ажиллагаанд явуулахтай холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон мэргэжлийн хяналтын байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг биелүүлж байх	Менежментийн баг		2025	
13		Ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтыг системтэй зохион байгуулах	Үйлдвэрийн бүх ажилчдад		2025	
Нийт				150,000₮		

4.6 Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хугацаа ба давтамж	Зардал	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Хатуу хог хаягдлыг ялгах, зайлуулах, дахин боловсруулалтад оруулах талаар менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	2025	250,000₮*10 сар=2.500.000	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд

2	Шингэн хог хаягдлаар хөрс, ус бохирдох	Шингэн хаягдлыг зайлуулж буй цэвэршүүлэх байгууламжтай холбогдож буй шугам хоолойн бүрэн бүтэн байдлыг байнга шалгаж засвар үйлчилгээг хийж байх, нийлүүлж буй бохир усны найрлагад хяналт тавих	Ашиглалтын хугацаанд	Ажиллагааны зардалд тусгах	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
3		Саармагжуулах хөрсний цэг байгуулах	2025		Хүнд металаар бохирдсон хөрсийг саармагжуулах арга зүй, технологи
4	Үнэрийн бохирдлоор агаар орчин бохирдох	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах		Ажиллагааны зардалд тусгах	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
Нийт				2,500,000₮	

БОМТ-ний хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах хувиар

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд ашиглалтын нэг жилдтөгрөгийг төсөвлөв.

4.7 БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАНГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

№	БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
1	Хорооны ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	10 сар	Нутгийн иргэдийн санал хавсаргах	-
2	БОЦУӨЯ-ны ХБОБНУГ-Т	-	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	11-р сар	-	-

4.8 Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр

№	Хяналтын үзүүлэлт		Хяналт шинжилгээ хийх байршил	Хяналтын давтамж	Шаардагдах зардал /мян.төг/	Баримтлах арга аргачлал, стандарт шаардлага
1	Агаарын чанар:	Тоосжилт	47.906680N 106.832443E 47.907083N 106.833230E 47,906399N 106.828976E	2удаа*3цэг	100000₮*3=300000	-MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
		Чимээний бохирдол	47,906399N 106.828976E	2удаа*1цэг	100000₮*1=100000	
		Агаарын бохирдол	47,906399N 106.828976E	2удаа*1цэг	100000₮*1=100000	
2	Усны хяналт шинжилгээ	Худгийн усны шинжилгээ	47.906399N 106.828997E	1удаа*1цэг	45000₮*1=45000	-MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж - MNS 0900:2010 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт - Газрын доорх ус бохирдуулагч бодис, элементийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт (MNS 6148:2010) - Гүний уснаас дээж авах зөвлөмж MNS (ISO) 5667-1:2002 - Усны чанар-Дээж авах: 1-р хэсэг. Дээж авах хөтөлбөр - MNS 6390:2013
		Хаягдал усны шинжилгээ	47.906399N 106.828976E	2удаа*1цэг	50000₮*2=100000	

3	Хөрсний шинжилгээ	Хими, физик шинж чанар	47.906680N 106.832443E	1удаа*1цэг	22000₮*1=22000	-MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага - MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга - MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
		Хүнд метал	47.906680N 106.832443E	1удаа*1цэг	25000₮*1=25000	
		Хөрсний эрүүл ахуй	47.906680N 106.832443E	1удаа*2 цэг	30000₮*2=60000	
			47,906607N 106.831372E			
Нийт					752000₮	

ХАВСРАЛТ НЭГ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

ХЯНАСАН ТОО	
Хяналт тавьсан мэргэжилтнүүдийн нэр	
Дүгнэлт • Шийдвэрийн төсөл • Ололт амжилт • Дутагдал сайжруулах шаардлага	

ХОЁР. ТӨСЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
1.1	Төсөл хэрэгжүүлэх ААН	“Монитал Кашемир” ХХК
	ААН-ийн улсын бүртгэлийн дугаар	9019003150
	Үйл ажиллагааны чиглэл	Ноолуур боловсруулах анхан шатны үйлдвэр
	ААН-ийн хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29-р хороо, Нөхөрлөлийн гудамж, 1-31
	Захирлын нэр, утас	Ж.Одончимэг 88113134
	Мэргэжилтний утас	Ц.Амарсайхан 95125038
1.2	Төслийн нэр	”Ноолуурын анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр”
	Төслийн байршил	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 29-р хороо, Нөхөрлөлийн гудамж, 1-31
	Төслийн ангилал	Ноос, ноолууранд анхан шатны боловсруулалт хийх үйлдвэр
	Төсөл эхэлсэн огноо	1997 оноос үйл ажиллагаа явуулж эхлэсэн
	Төсөл хэрэгжих хугацаа	5 жил
	Өмнөх оны нийт бүтээгдэхүүний хэмжээ	120тн

ГУРАВ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
2.1	Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл Хүчинтэй хугацаа Талбай	Шаардлагагүй 5 жил 18213м/кв
	Тусгай зөвшөөрлийн төрөл	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл-0001140
	Химийн бодис хадгалах байрны дүгнэлтийн дугаар	08/691 В/27
	Галын дүгнэлтийн огноо	Дугаар 0027634 Хяналт хийсэн огноо: 2025.04.13 Олгосон:2025.04.30 Хүчинтэй хугацаа: 2026.04.30
	БОННУ батлагдсан огноо батласан хуулийн этгээд	БОУАӨЯам 2025.05.15 “Текол” ХХК
	Газар ашиглалтын гэрээ огноо, хуулийн этгээд	2024.08.13 Нийслэлийн засаг даргын захирамж А/21 тоот ААН-д газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний дугаар- 0000161855
	Тухайн жилд баримталж ажиллах стандартын дугаар	-MNS 5563 - 2005 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрт тавигдах ерөнхий шаардлага -MNS 6390-2013 Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус - MNS 4251 - 2008 Ноос, ноолуур. Үйлдвэрлэлийн технологийн хаягдал, Сэв хялгас, богино ноолуур. Техникийн шаардлага. - MNS 0215 – 2007 Ноос, ноолуур. Савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх. Техникийн шаардлага
	Ус ашиглах гэрээний огноо	2024 оны 12 сарын 06 өдөр Дугаар 2024/114 Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Байгаль орчны газрын ус ашиглуулах дүгнэлт

ДӨРӨВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл																																																																																									
3.1	Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ	<table><tr><th colspan="2">Бодисын нэршил</th><th rowspan="2">Томъёо</th><th rowspan="2">CAS дугаар</th><th colspan="3">Хэрэглээ</th></tr><tr><th>Монгол</th><th>Олон улсын</th><th>Хэмжих нэгж</th><th>өдөрт</th><th>жилд</th></tr><tr><td>Хөнгөн цагааны хлорид</td><td>Aluminum polychlorid (18%)</td><td>$(Aln(OH)LnCl_{3-n})_m$</td><td>1327-41-9</td><td>кг</td><td>1.1</td><td>13500</td></tr><tr><td>Хөнгөн цагааны полихлорид</td><td>Aluminum polychlorid</td><td>$Aln(OH)MC_{13-n}m$</td><td></td><td>кг</td><td>1.4</td><td>400</td></tr><tr><td>Полиэлектролит</td><td>Polyelectrolite, Caffoc668</td><td>$(CH_2NO)_m$</td><td>9003-05-8</td><td>кг</td><td>3.5</td><td>1000</td></tr><tr><td>Полиакриламид анион</td><td>Polyacrylamide anion</td><td>$CH_2-CH_2(CONH_2)_n$</td><td>9003-05-8</td><td>кг</td><td>2.14</td><td>600</td></tr><tr><td>Полиакриламид катин</td><td>Polyacrylamide cation</td><td>$CH_2-CH_2(CONH_2)_n$</td><td>9003-05-8</td><td>кг</td><td>1.07</td><td>300</td></tr><tr><td>Ноолуур угаах шингэн саван</td><td>Detergent, Teridol B CONC</td><td>$RO(OC_2H_4)_nH$</td><td></td><td>литр</td><td>15</td><td>3000</td></tr><tr><td>Ноолуур угаах шингэн саван</td><td>Detergent, Teridol ER (Mixture)</td><td>$RO(OC_2Y_2m)H$</td><td></td><td>литр</td><td>15</td><td>3000</td></tr><tr><td>Сода</td><td>Sodium carbonate</td><td>Na_2CO_3</td><td>497-19-8</td><td>кг</td><td>10</td><td>2000</td></tr><tr><td>Антистатик</td><td>Ricostat 27</td><td></td><td></td><td>литр</td><td>0.3</td><td>18</td></tr><tr><td>Диэтилийн спирт</td><td>Diethyl ether</td><td>$(C_2H_5)_2O$</td><td>60-29-7</td><td>литр</td><td>0.3</td><td>18</td></tr><tr><td>Дихлор метан</td><td>Dichloromethane</td><td>CH_2Cl_2</td><td>75-09-2</td><td>литр</td><td>0.3</td><td>18</td></tr></table>	Бодисын нэршил		Томъёо	CAS дугаар	Хэрэглээ			Монгол	Олон улсын	Хэмжих нэгж	өдөрт	жилд	Хөнгөн цагааны хлорид	Aluminum polychlorid (18%)	$(Aln(OH)LnCl_{3-n})_m$	1327-41-9	кг	1.1	13500	Хөнгөн цагааны полихлорид	Aluminum polychlorid	$Aln(OH)MC_{13-n}m$		кг	1.4	400	Полиэлектролит	Polyelectrolite, Caffoc668	$(CH_2NO)_m$	9003-05-8	кг	3.5	1000	Полиакриламид анион	Polyacrylamide anion	$CH_2-CH_2(CONH_2)_n$	9003-05-8	кг	2.14	600	Полиакриламид катин	Polyacrylamide cation	$CH_2-CH_2(CONH_2)_n$	9003-05-8	кг	1.07	300	Ноолуур угаах шингэн саван	Detergent, Teridol B CONC	$RO(OC_2H_4)_nH$		литр	15	3000	Ноолуур угаах шингэн саван	Detergent, Teridol ER (Mixture)	$RO(OC_2Y_2m)H$		литр	15	3000	Сода	Sodium carbonate	Na_2CO_3	497-19-8	кг	10	2000	Антистатик	Ricostat 27			литр	0.3	18	Диэтилийн спирт	Diethyl ether	$(C_2H_5)_2O$	60-29-7	литр	0.3	18	Дихлор метан	Dichloromethane	CH_2Cl_2	75-09-2	литр	0.3	18
	Бодисын нэршил		Томъёо	CAS дугаар			Хэрэглээ																																																																																				
Монгол	Олон улсын	Хэмжих нэгж			өдөрт	жилд																																																																																					
Хөнгөн цагааны хлорид	Aluminum polychlorid (18%)	$(Aln(OH)LnCl_{3-n})_m$	1327-41-9	кг	1.1	13500																																																																																					
Хөнгөн цагааны полихлорид	Aluminum polychlorid	$Aln(OH)MC_{13-n}m$		кг	1.4	400																																																																																					
Полиэлектролит	Polyelectrolite, Caffoc668	$(CH_2NO)_m$	9003-05-8	кг	3.5	1000																																																																																					
Полиакриламид анион	Polyacrylamide anion	$CH_2-CH_2(CONH_2)_n$	9003-05-8	кг	2.14	600																																																																																					
Полиакриламид катин	Polyacrylamide cation	$CH_2-CH_2(CONH_2)_n$	9003-05-8	кг	1.07	300																																																																																					
Ноолуур угаах шингэн саван	Detergent, Teridol B CONC	$RO(OC_2H_4)_nH$		литр	15	3000																																																																																					
Ноолуур угаах шингэн саван	Detergent, Teridol ER (Mixture)	$RO(OC_2Y_2m)H$		литр	15	3000																																																																																					
Сода	Sodium carbonate	Na_2CO_3	497-19-8	кг	10	2000																																																																																					
Антистатик	Ricostat 27			литр	0.3	18																																																																																					
Диэтилийн спирт	Diethyl ether	$(C_2H_5)_2O$	60-29-7	литр	0.3	18																																																																																					
Дихлор метан	Dichloromethane	CH_2Cl_2	75-09-2	литр	0.3	18																																																																																					
	Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Байгаа																																																																																									
3.2	Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх Тэсрэх дэлбэрэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	-																																																																																									
3.3	Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж - Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ - Аюултай хог хаягдал	Ахуйн хог хаягдал -45тн орчим Аюултай хог хаягдал -50кг орчим																																																																																									
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төсөв	2,500,000₮																																																																																									

ТАВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ

№	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
4.1	Тухайн жилийн менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	4 822 000₮
	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	900 000₮
	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	370 000₮
	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
	Осол, эрсдэлийн болон удирдлага зохион байгуулалтын Төлөвлөгөө	150 000:
	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2 500 000₮
	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	752 000₮
	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	150 000₮

ЗУРГАА. ДАТА МЭДЭЭЛЭЛ

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл
5.1	Хөрсний шижилгээний дээж авах цэг	47.906680N
		106.832443E
		47.906680N
		106.832443E
	Усны шинжилгээний дээж авах цэг	47.906399N
		106.828997E
	Агаарын шинжилгээний дээж авах цэг	47.906399N
		106.828976E
		47.906680N
		106.832443E
		47.907083N
		106.833230E
		47.906399N
		106.828976E

ДОЛОО. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН

Нөлөөллийн ангилал	А. Тооцсон эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлсон эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл рдуулах ➤ Эвдэх ➤ Доройтуулах	Тодорхой л сон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл ➤ Бохирдуулах ➤ Нөөцийг бууруулах	Тодорхой л сон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
Амьтан ургамалд үзүүлэх нөлөөлөл ➤ Амьдрах орчинг хуваах ➤ Амьдрах орчинг доройтуулах ➤ Амьдрах орчинг хомсдуулах ➤ Нөөцийг бууруулах	Тодорхой л сон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
Агаарт үзүүлэх нөлөөлөл ➤ Бохирдуулах	Тодорхой л сон	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлсон	
Түүх соёлын дурсгалт зүйлс ➤ Хамгаалах ➤ Нүүлгэн шилжүүлэх	-	-	-	-	

НАЙМ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨӨНИЙ ДҮН

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	Тоо	Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	Шалгуур үзүүлэлтийг хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Дүгнэлт
Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	15			
Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	21			
Төслийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	2			

МЭДЭЭЛЭЛ ГАРГАСАН:

“МОНИТАЛ КАШЕМИР” ХХК-ИЙН СТАНДАРТ, БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Ц.АМАРСАЙХАН